

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод их сургуулийн харьяа Дорнод ахлах сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: **ДОА-2021/157/СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Гэрээт аудитор: Б.Оюунхэрлэн

Утас: 7058-4204, Цахим хаяг: oyunkherlenb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3. Аудитын тайлан	10
3.1. Ерөнхий зүйл	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	11
3.4. Материаллаг байдал	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	12
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	12
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.9. Аудитын илрүүлэлт.....	13
Залруулсан алдаа	13
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	13
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	Error! Bookmark not defined.
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	14

1.Хараат бус аудиторын дүгнэлт



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын И байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.23 № 212
танай _____ -ны № _____ -т

ДОРНОД ИХ СУРГУУЛИЙН ХАРЬЯА
ДОРНОД АХЛАХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Ш.МАНДАХ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод ахлах сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод ахлах сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дорнод ахлах сургуулийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт дүгнэгдээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

011021290



Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	00.00	9,086,064.00
33	АВЛАГА	00.00	288,689.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	288,689.00
35	БАРАА МАТЕРИАЛ	00.00	8,797,375.00
354	Хангамжийн материал	00.00	8,797,375.00
35470	Бусад хангамжийн материал	00.00	8,797,375.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	00.00	26,808,926.93
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	00.00	26,808,926.93
392	Биет хөрөнгө	00.00	24,936,635.25
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	00.00	26,609,352.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-3,616,279.23
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	00.00	2,297,625.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-354,062.52
393	Биет бус хөрөнгө	00.00	1,872,291.68
39301	Програм хангамж	00.00	2,310,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-437,708.32
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	00.00	35,894,990.93
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	288,689.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	288,689.00
413	Өглөг	00.00	288,689.00
4136	Бусад өглөг	00.00	288,689.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	288,689.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	00.00	35,606,301.93
51	Засгийн газрын хувь оролцоо	00.00	35,606,301.93
512	Хуримтлагдсан үр дүн	00.00	35,606,301.93
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	35,606,301.93
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	00.00	35,894,990.93

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	00.00	206,640,438.04
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	38,683,639.50
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	8,676,662.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	8,676,662.50
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	8,676,662.50
121	Хөрөнгийн орлого	00.00	30,006,977.00
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	00.00	30,006,977.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	00.00	36,695,898.54
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	131,260,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	36,695,898.54
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	36,695,898.54
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	00.00	171,034,136.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	00.00	171,034,136.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	00.00	164,309,752.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	00.00	134,400,631.00
210101	Үндсэн цалин	00.00	121,319,531.00
210102	Нэмэгдэл	00.00	7,141,100.00
210104	Урамшуулал	00.00	5,940,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	00.00	16,387,300.00
210201	Тэтгэврийн даатгал	00.00	11,598,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	1,197,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	957,760.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	239,440.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	2,394,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	00.00	2,158,437.93
210401	Бичиг хэрэг	00.00	444,320.76
210402	Тээвэр, шатахуун	00.00	200,000.00
210404	Ном, хэвлэл	00.00	756,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	758,117.17
2105	Нормативт зардал	00.00	6,272,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	10,500.00
210502	Хоол, хүнс	00.00	6,262,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	292,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	292,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	4,798,483.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	100,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	290,433.33
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	00.00	4,408,050.07
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	6,724,383.78
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	6,724,383.78
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	6,724,383.78
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	00.00	35,606,301.93
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	00.00	35,606,301.93

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	00.00	167,956,798.54
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	00.00	167,956,798.54
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	131,260,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	36,695,898.54
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	36,695,898.54
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	00.00	167,956,798.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	00.00	167,956,798.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	00.00	161,232,414.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	00.00	134,400,631.00
210101	Үндсэн цалин	00.00	121,319,531.00
210102	Нэмэгдэл	00.00	7,141,100.00
210104	Урамшуулал	00.00	5,940,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	00.00	16,387,300.00
210201	Тэтгэврийн даатгал	00.00	11,598,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	1,197,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	957,760.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	239,440.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	2,394,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	00.00	2,157,483.76
210401	Бичиг хэрэг	00.00	444,320.76
210402	Тээвэр, шатахуун	00.00	200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	89,000.00
210404	Ном, хэвлэл	00.00	756,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	668,163.00
2105	Нормативт зардал	00.00	6,324,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	10,500.00
210502	Хоол, хүнс	00.00	6,262,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	52,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	1,502,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	1,502,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	460,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	100,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	360,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	6,724,383.78
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	6,724,383.78
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	6,724,383.78

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	35,606,301.93	00.00	35,606,301.93
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	35,606,301.93	00.00	35,606,301.93

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Монго, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	00.00	00.00	131,260,900.00	131,260,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	00.00	00.00	131,260,900.00	131,260,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	00.00	00.00	131,260,900.00	124,536,516.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	00.00	00.00	115,501,000.00	108,841,394.00
210101	Үндсэн цалин	00.00	00.00	102,419,900.00	95,760,294.00
210102	Нэмэгдэл	00.00	00.00	7,141,100.00	7,141,100.00
210104	Урамшуулал	00.00	00.00	5,940,000.00	5,940,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	00.00	00.00	14,437,600.00	14,437,600.00
210201	Тэтгэврийн даатгал	00.00	00.00	9,817,600.00	9,817,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	00.00	1,155,000.00	1,155,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	00.00	924,000.00	924,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	00.00	231,000.00	231,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	00.00	2,310,000.00	2,310,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	00.00	00.00	775,200.00	710,422.22
210401	Бичиг хэрэг	00.00	00.00	106,100.00	83,022.22
210402	Тээвэр, шатахуун	00.00	00.00	241,700.00	200,000.00
210403	Шуудан, холбоо, ингэрнэтийн төлбөр	00.00	00.00	52,100.00	52,100.00
210404	Ном, хэвлэл	00.00	00.00	41,700.00	41,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	00.00	333,600.00	333,600.00
2105	Нормативт зардал	00.00	00.00	62,600.00	62,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	00.00	10,500.00	10,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	00.00	52,100.00	52,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	00.00	24,500.00	24,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	00.00	24,500.00	24,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00	460000.00	460000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	00.00	100,000.00	100,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	00.00	360,000.00	360,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	00.00	00.00	131,260,900.00	131,260,900.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	00.00	131,260,900.00	131,260,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	00.00	131,260,900.00	131,260,900.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих				
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	00.00	00.00	11.00	11.00
620001	Удирдах ажилтан	00.00	00.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	00.00	00.00	10.00	10.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	00.00	00.00	75.00	75.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	00.00	00.00	75.00	75.00
630001	Төрийн өмчит ЕБС	00.00	00.00	75.00	75.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		36,695,898.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ		36,695,898.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		36,695,898.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		25,559,237.00
210101	Үндсэн цалин		25,559,237.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,949,700.00
210201	Тэтгэврийн даатгал		1,780,900.00
210202	Тэтгэмжийн даатгал		42,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		33,760.00
210204	Ажилгүйдлийн даатгал		8,440.00
210205	Эрүүл мэндийн даатгал		84,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал		1,447,061.54
210401	Бичиг хэрэг		361,298.54
210403	Шуудан, холбоо, интэрнэгийн төлбөр		36,900.00
210404	Ном, хэвлэл		714,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		334,563.00
2105	Нормативт зардал		6,262,000.00
210502	Хоол, хүнс		6,262,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр		1,477,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,477,900.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	36,695,898.54
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		36,695,898.54
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		36,695,898.54
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)-(II)-(I)		

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дорнод их сургуулийн харьяа Дорнод ахлах сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Ш.Мандах танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-ноос 2021 оны 02 дүгээр сарын 24-ны хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор Б.Оюунхэрлэн хариуцаж хэрэгжүүлэв.

Дорнод ахлах сургууль 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Дорнод ахлах сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Бүрэн дунд боловсрол олгох

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Дорнод ахлах сургууль нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү, хяналт аудитын алба 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дорнод ахлах сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 171,034.1 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 3,420.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	288.7	288.7-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал		8,797.4	8,797.4
Үндсэн хөрөнгө		26,808.9	26,808.9
Нийт хөрөнгө		35,895.0	35,895.0
Өр төлбөр		288.7	288.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/		35,606.3	35,606.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн		35,895.0	35,895.0

. Авлага дансны үлдэгдэл 288.7 байгаа хөгжлийн бэрхшээлтэй ажилчдад олгосон ХХОАТ-ыг татварын байгууллагаас буцаан авлага үүсгэсэнтэй холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 8,797.4 мянган төгрөг байгаа нь хандиваар 8,676.7 мянган төгрөгийн бараа материал, төсвийн хөрөнгөөр 950.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 829.5 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалжээ.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 256,009.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 256,009.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 124,748.1 мянган төгрөгөөр бууруулж 131,260.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 131,260.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 131,260.9 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 131,260.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 124,536.5 мянган төгрөгийг зарцуулж 6,724.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 124,536.5 мянган төгрөг буюу 94.9 хувьтай байгаа нь 6,724.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 36,695.9 мянган төгрөгийн сурагчдын хоолны мөнгө орсон бөгөөд бараа үйлчилгээний зардалд зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд 147 мэдээллээс 34 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант онд бие даасан байгууллага болсон тул өмнө нь аудитын дүгнэлт аваагүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 237,816.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд 3 албан шаардлага, хүргүүлсэн.

Залруулсан алдаа

Аудитаар хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос 288.7 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутган тооцож, татварт төлсөн зөрчилд авлага, өглөг үүсгүүлж залруулга хийсэн.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар нийт 237,816.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа зөрчилд 3 албан шаардлага хүргүүлээ.

1. Тайлант онд шилэн дансанд байршуулбал зохих 147 мэдээллээс 34 мэдээлэл хугацаа хоцроон мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 3.1 Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна:3.1.1 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд; 3.1.2 төрийн өмчит үйлдвэрийн газар; 6.1 Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ: 6.1.1.тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор; 6.1.2 хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор; 6.1.3 дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор; 6.1.4 жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор 6.1.5 төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор; 6.1.6 төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр мэдээлнэ гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг зөрчин хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос нийт 288.7 мянган төгрөгийн татвар суутгасан нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх "дараах орлогыг албан татвараас чөлөөлнө", 22.1.2 дахь "хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого", Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх "хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах, ..." гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.



3. Тайлант онд нийт худалдан авалтынхаа 33.9 хувийг НӨАТ-ын баримтгүй хийсэн нь СС-ын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг хэвлэнэ гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Дорнод их сургуулийн харьяа Дорнод ахлах сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код:
2020			ДОА-2021/157/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<i>Дорнод их сургуулийн харьяа Дорнод ахлах сургууль</i>		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Худалдан авалтын 33.9 хувийг НӨАТ-ын баримтгүй хийсэн	890.4	Албан шаардлага	Захирал Нягтлан бодогч	Ш.Мандах Г.Цэрэнсодном
	Шилэн дансны сайтад оруулбал зохих 147 мэдээллээс 34 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.	236,637.1	Албан шаардлага	Эрхлэгч, нягтлан бодогч	Ш.Мандах Г.Цэрэнсодном
	Хөгжлийн бэрхшээлтэй хүнд олгосон цалингаас ХХОАТ-ыг суутгасан.	288.7	Албан шаардлага	Эрхлэгч, нягтлан бодогч	Ш.Мандах Г.Цэрэнсодном
	ДҮН	237,816.2			

